<p>6.6.стратегийн болон бусад томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэнд оруулахтай холбогдуулан Таван толгой, Оюу толгой орчмын нутагт шинээр байгуулагдах хот, суурингийн хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулах;</p>	<p>6.7.хот төлөвлөлт, барилгын зураг төсөл боловсруулах, инженер хайгуулын судалгаа хийх аж ахуйн нэгж, байгууллагуудын бүтцийг боловсронгуй болгож, чадавхийг дээшлүүлэх;</p>	<p>үйл ажиллагааны хэрэгжилтээр</p>	<p>-</p>
<p>6.8.орон нутгийн эрдэс түүхий эдийн нөөцөд тулгуурлан барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, Хөтөлийн цементийн үйлдвэрт техник, тонсг төхөөрөмжийн шинэчлэлт хийж, үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх;</p>	<p>6.9.бүсийн тулгуур төв болон хилийн томоохон боомтуудад барилгын материалын чанарын лабораторийг байгуулж, ажиллуулах;</p>	<p>цементийн үйлдвэрлэлийн хүчин чадал (сая тонн)</p>	<p>1.0</p>
<p>6.10 шинээр баригдаж эхлэх хорооллын бэлтгэл ажлыг хангах хүрээнд хот, суурин газрын инженерийн шугам сүлжээг сайжруулах.</p>	<p>Буюнт-Ухаад шинээр баригдах орон сууцны хорооллын төвлөрсөн дулааны шугамд холбогдох өрхийн тоо</p>	<p>орлоготон шинэчлэх бохир усны шугамын хоолойн урт /метр/</p>	<p>9000</p>
<p>Зорилт 7. Зам, тээвэр, харилцаа холбоо нь эдийн засгийн хөгжил, хүн амын амьдралын чухал нөхцөл тул дэд бүтцийн салбарыг хөгжүүлэхэд анхаарлага илүү хандуулна:</p>	<p>7.1.эдийн авто замын сүлжээний АН-32, АН-4, АН-3 чиглэлийн болон Мянганы замын хэвтээ, босоо тэнхлэгийн авто замын ажлыг эрчимжүүлэх, Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Цөгр -Замын-Үүд, Булган-Үенчийн чиглэлийн зам барих ажлыг үргэлжлүүлэх; • Баян-Өлгий -Ховдын чиглэлд хатуу хучилттай зам барих; 	<p>ашиглалтанд орох авто замын урт /км/</p>	<p>432</p>
	<p>барих замын урт /км/</p>		<p>15</p>

<ul style="list-style-type: none"> Өндөрхаан-Сумбар, Тэрхийн гуур-Их-Уул, Баянхонгор-Нарийн тээл, Арвайхээр-Баянхонгор, Хануйн гуур-Халзан бургадийг-Тэрхийн гуур, Өлгий-Цагааннуур, Дашинчилан-Орхоны гуур, Хөшөөцайдам-Өгийнуур чиглэлийн замуудыг үргэлжүүлэн барих; 	<p>ашиглалтанд орох автозамын урт /км/</p>	<p>374</p>
<p>7.2.босоо тэнхлэгийн замын хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх; 7.3.эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр авто зам, гүүрийн барилга байгууламж барих ажлыг дэмжих; 7.4.нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг сайжруулах, автогээврийн хэрэгсээс хүрээлэн буй орчин, хүн ам, замын хөдөлгөөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах.</p>	<p>үйл ажиллагааны хэрэгжилтээр үйл ажиллагааны хэрэгжилтээр</p>	<p>- -</p>
<p>Зорилт 8. Бүх төрлийн тээврийн хөгжил эрчимжих нөхцөлийг бүрдүүлж, аялал жуулчлалын салбарыг хөгжлийн нэг томоохон гарц гэж үзэж тулхуу хөгжүүлнэ:</p>	<p>үйл ажиллагааны хэрэгжилтээр</p>	<p>-</p>
<p>8.1.улсын чанартай болон хот хороондын гол замуудын дагуу 100-150 км тутамд үйлчилгээний тохилог цогцлолбор барих хөтөлбөр, төслийн техник, эдийн засгийн үндэслэл, судалгаа, зураг төслийг боловсруулж, хөтөлбөр, төслийг эхлүүлэх, замын засвар, арчлалтыг тогтмолжуулж, тэмдэжүүлэх;</p>	<p>үйл ажиллагааны хэрэгжилтээр</p>	<p>-</p>
<p>8.2.говийн болон зүүн бүсийн төмөр замын сүлжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулах;</p>	<p>техник эдийн засгийн үндэслэл боловсругдсон байх</p>	<p>-</p>
<p>8.3.Улаанбаатар төмөр замын техник, технологийг шинэчилж, тээх, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, Манганы сорилтын сангийн Төмөр замын тээврийг сэргээх төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх;</p>	<p>төслийн ажил эхэлсэн байх</p>	<p>-</p>
<p>8.4.төмөр замын хос шугам барих асуудлыг судалж, хэрэгжүүлж эхлэх;</p>	<p>-</p>	<p>-</p>
<p>8.5.Төв аймгийн Хөшигийн хөндийд олон улсын нисэж буудлын дэд бүтэц барих ажлыг эхлүүлэх;</p>	<p>барилгын ажил эхэлсэн байх</p>	<p>-</p>
<p>8.6.аялал жуулчлалын үйлчилгээний стандартуудыг шинэчлэн мөрдүүлэх, байгаль орчинд халгүй аяллын төрлийг хөгжүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулан, жуулчдын хүлээн авах болон дамжин өнгөрөх хүчин чадлыг нэмэгдүүлэх;</p>	<p>жуулчдын хүлээн авах хүчин чадлын нэмэгдэх хувь</p>	<p>4.0</p>
<p>8.7.аялал жуулчлалын үйл ажиллагааг зохицуулсан төрийн өмчит улсын үйлдвэрийн газар байгуулах;</p>	<p>хүлээн авах жуулчдын тоо /мянга/</p>	<p>500.0</p>
<p>8.8.аялал жуулчлалыг хөгжүүлэх ажлын хүрээнд Хөвсгөл нуурт усан замын тээврийн хэрэгсэл зорчих чиглэл, маршруттыг тогтоож, тэмдэжүүлэх, тээврийн хэрэгсэлийн тусгай зогсоол барих;</p>	<p>үйл ажиллагааны хэрэгжилтээр</p>	<p>-</p>
<p>8.9.өвөн нэмэгдэж буй тээврийн үйл ажиллагааг зохицуулах ажлын хүрээнд Замын-Үүдийн боомтын тээх, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх чиглэлээр олон улсын байгууллагатай хамтран ажиллах;</p>	<p>үйл ажиллагааны хэрэгжилтээр</p>	<p>-</p>

	<p>үйл ажиллагааны хэрэгжилтээр</p>	
<p>үйл ажиллагааны хэрэгжилтээр</p>	<p>үйл ажиллагааны хэрэгжилтээр</p>	
<p>үйл ажиллагааны хэрэгжилтээр</p>	<p>үйл ажиллагааны хэрэгжилтээр</p>	
<p>үйл ажиллагааны хэрэгжилтээр</p>	<p>үйл ажиллагааны хэрэгжилтээр</p>	
<p>үйл ажиллагааны хэрэгжилтээр</p>	<p>үйл ажиллагааны хэрэгжилтээр</p>	<p>10.0 12 300 5 500 19</p>
<p>үйл ажиллагааны хэрэгжилтээр</p>	<p>үйл ажиллагааны хэрэгжилтээр</p>	<p>6 25</p>
<p>Тусгай хамгаалалтанд хамрагдах голын эхийн тоо</p>		
<p>Хяналт, шинжилгээний сүлжээ байгуулах тоо</p>		

ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧИН, БУС НУТАГ, ХӨДӨӨГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Зорилт 10. Байгалийн нөөц байлгийн менежментийн эрх зүйн үндсийг боловсронгуй болгон, байгаль орчныг хамгаалахад олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ:

10.1.Байгалийн нөөц байлгийг тогтвортой ашиглах, хүрээлэн буй орчныг нөхөн сэргээх, хамгаалах урт хугацааны бодлого боловсруулж хэрэгжүүлэх, байгаль орчинд халтгай дэвшилтэт техникийн, технологийн нэвтрүүлэхийг бодлогоор дэмжих, хэрэгжилтэд хяналт тавих;

10.2.Байгалийн нөөцийг үр нөлөөтэй ашиглах эрх зүйн орчныг бүрдүүлж, стратегийн удирдлагын чадварыг бэхжүүлэх;

10.3.мэргэжлийн байгууллага, олон нийтийн оролцоонд түшиглэн ой бүхий талбайг эзэмшүүлэх үндсэн дээр ойг нөхөн сэргээх, хамгаалах менежментийг бүрдүүлэх;

10.4.ойжуулалт, мод үржүүлгийн ажлын чанарыг дээшлүүлэх, хууль бусаар мод болгохтой тэмцэх, ойн түмэрээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх;

10.5.ойн цэвэрлэгээ хийж замаар түймэрт шатсан болон өмхөрч, өгөршсөн унагн модыг цэвэрлэж түшигэнд хэрэглээг тогтолцоог бий болгох;

10.6.голсуудын сав газрын менежментийн зөвлөлийг байгуулах, зарим голын эхийг тусгай хамгаалалтад авах;

10.7.газрын доорхи усны мониторингийн судалгаа явуулах, усны хяналт-шинжилгээний сүлжээг бүрдүүлж, ажиллах.

10.8.Бүсүүдийн тулгуур төв болон хот, суурин газрын усан хангамжийн эх үүсвэрийн эрэл хайгуул, судалгааны ажлыг явуулж, нөөцийн хэмжээг тогтоох; 10.9.ан амьтны тархал, нөөцийг тогтоож, хамгаалах менежментийг боловсронгуй болгох ажлын хүрээнд иргэд, аж ахуйн нэгжийн ан амьтны хамгаалах, өсгөн үржүүлэх санаачлагыг дэмжих; 10.10.биологийн төрөл зүйлийг хамгаалах, ТХГН-ийн менежментийг бэхжүүлэх, авяал жуулчлал хөгжүүлэх үйл ажиллагаанд иргэдийг өргөн оролцуулсан хамтын менежментийг боловсронгуй болгох.	эрэл, хайгуул явуулах газрын тоо идэвхтэй үйл ажиллагаа явуулах нөхөрлөлийн тоо	7 3
Зорилт 11. Агаар, Ус, хөрсний бохирдол, орчны доройлтыг бууруулах, хянах тогтолцоог боловсронгуй болгоно:	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-
11.1.Бохирдуулагч нь төлбөр төлөх зарчмыг хэрэгжүүлж, агаарын чанарыг хангах арга хэмжээг санхүүжүүлэх, оновчтой арга хэлбэрийг нэвтрүүлэх;	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-
11.2.хүрээлэн буй орчны хяналт, шинжилгээ, судалгааны нэгдсэн сүлжээг өргөжүүлэх, лабораторийн мэргэжлийн албаны чадварыг бэхжүүлэх;	нэмж байгуулах болон шинэчлэн тоноглоосон лаборатори, нэгжийн тоо	2
11.3.хяналт, шинжилгээ, судалгааны нэгдсэн сүлжээг өргөжүүлэх, агаарын бохирдлоос хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийн талаар үнэлгээ хийх;	агаар бохирдуулах эх үүсвэрийн хяналт, шинжилгээний лаборатори	1
11.4.газрын нэгдмэл сангийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгон газрыг ур ашигтай ашиглах, хамгаалах эрх зүйн үндэсний боловсронгуй болгох;	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-
11.5.газрын нэгдсэн төлөөлөгөөр Улсын Их Хурлаар батлуулах, нийслэл, аймгуудын төв болон төвлөрсөн суурингийн гэр хорооллыг барилгажуулахаас бусад газруудыг зөвхөн нээлттэй дүүдлага худалдаагаар худалдах тогтолцоонд шилжих;	-	-
11.6.GPS-ийн технологийг нэвтрүүлэх, Монгол Улсын GPS-ийн сүлжээ байгуулах 2 дахь шатны ажлыг хийх, өндрийн сүлжээг сайжруулах;	зурдлалын ажлын чанар сайжрах нөхцөл бүрдэнэ	-
11.7.говь, хээр, цөлжилт ихээр явагдаж байгаа бүс нутгуудад усны нөөцийг нэмэгдүүлэх, мод, бут сөөг тарьж ургуулах ажлыг эрчимжүүлэх;	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-
11.8.говь, хээрийн цөлжилт ихээр явагдаж байгаа бүсүүдэд баянбурд үүсгэх, худал ус гаргах, усжуулах бүхий л санал, санаачлагыг дэмжих, "Ус" хөтөлбөрийг үргэжлүүлэн хэрэгжүүлэх, хөдөөгийн баг бүрт сүүлчин үеийн дэвшилтэт технологийг ашиглан шинээр 1 худал нэмж гаргах ажлыг эхлүүлэх;	-	-
11.9.уул урхайн үйлдвэрлэлийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний шаардлагын хэрэгжилтэд тавих хяналтыг чангатаснаар олборлолтод өртсөн эдлэлэр газрыг нөхөн сэргээх хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох;	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-
11.10.алтны бага нөөцтэй шороон орд, усны хагалбар, голын ай сав газар, ойн сам, говийн баянбурд, байгалийн онцгой тогтоц бүхий газрууд, түүний хамгаалалтын бусад ашиглалтын тусгуй зөвшөөрөл олгосон байдлыг үе шаттайгаар зогсоож эхлэх, байгаль орчин, хүний эрүүл мэндэд халтай технологийг үе Уул урхайн үйлдвэрлэл явуулахыг бүрэн зогсоох;	үйл ажиллагааны х., эгжилтээр	-
11.11.үйлдвэрлэл, үйлчилгээний менежментийг боловсронгуй болгож, хот хангалын хэмжээг багасгах, дахин ашиглах, томоохон хот, суурин газруудын хот хангалын зориулалтын төвлөрсөн цэгийг байгуулах, ландшафллын аргыг нэвтрүүлэх;	томижуулах хөг, хаягдлын төвлөрсөн цэгийн тоо	1

11.12.хот, суурингийн хөрсний бохирдлын талаар нэрийнчилсэн судалгаа хийж, мэдээллийг нэгдсэн сан бүрдүүлэх.	сан байгуулагдсан байх	-
11.13.нүүдсийг хийжүүлэх, хагас кокс болгон боловсруулах, бүрэн шаталттай түлш хэрэглэдэг автоташин, нийтийн тээврийн хэрэгслийг дэмжих замаар Улаанбаатар хотын агаарын бохирдлыг багасгах.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-
11.14.химийн хортой болон аюултай бодисын менежментийг сайжруулах, зориулалтын байгууламж бүхий төвлөрсөн цэг байгуулах бэлтгэлийг хангах.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-
11.15.байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний чанар, үр дүнг нэмэгдүүлж, олон нийтийн хяналтын орлоцог өргөтгөх.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-
11.16.ус эмхэнх, бохир усыг цэвэршүүлэх техник, технологийн хөрөнгө оруулалтыг дэмжих.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-
11.17.ур амьсгалын өөрчлөлтийн таагүй нөлөөллийг бууруулах, Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох бодлого, стратеги боловсруулан хэрэгжүүлэх.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-
11.18.цэг агаарт зориудаар нөлөөлөх замаар хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах.	хөдөлгөөнт багийн тоо газрын генератор	2 1
Зорилт 12. Эдийн засгийн бүсчилсэн хөгжлийг дэмжих, хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан хот, тосгоныг хөгжүүлэх:		
12.1.Орхон-Сэлэнгэ-Дарханы эрчимтэй хөгжлийн бүсийн үйлдвэрлэл, үйлчилгээний бүтцийг бүрдүүлэх.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-
12.2.говийн бус нутагт Оюу толгой, Таван толгой, Цагаан суваргын ашигт малтмалын нөөцийг цогцоор ашиглахад чиглэсэн экспортын үйлдвэрлэлийн бүс байгуулах, дэд бүтцийн үндсэн сүлжээ бүрдүүлж эхлэх.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-
12.3.Алтанбулаг, Замын-Үүд, Цагааннуурын чөлөөт бүсэд түшиглэн эдийн засаг, экспортын өслтийг дэмжих хөрөнгө оруулалтын төслийг хэрэгжүүлж эхлэх.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-
12.4. Улаанбаатар хотын хүн амын хэт ачааллыг багасгаж, дагуул хотууд болох Багануур, Налайх, Багахангайг хөгжүүлэх, тэдгээрт зохистой төвлөрлийг бий болгох.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-
12.5.Улаанбаатар хотыг шинэчлэн хөгжүүлэх "Шинэ Улаанбаатар-Ногоон нийслэл" хөтөлбөр батлах, нийслэлд агаар болон хөрсний бохирдлыг бууруулах, дэд бүтэц, хотны асуудлыг иж бүрэн шийдвэрлэх, хот байгуулалт, хот төлөвлөлтийн бодлогыг шинэчлэн баталж, хүүхэд, залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх цэцэрлэгт хүрээлэнг дүүрэг бүрт байгуулах ажлыг эхлүүлэх.	барилтын ажил эхэлсэн байх	-
12.6.Дорноговь аймгийн Замын-Үүдэд цэвэр, бохир ус, дулааны шугам сүлжээ, ус цэвэршүүлэх станц, цэвэрлэх байгууламж, дулааны станц барих ажлыг эхлүүлэх.		-
ДОРОВ, ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ, ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ХАНГАХ БОДЛОГО		
Зорилт 13. Хүн амын хөгжлийг ханган, хүний амьдралын чанарыг дээшлүүлэх:		
13.1.хүн амын өсөлтийг дэмжих хүрээнд хүүхдийн мөнгө, шинэ гэр бүл, шинэ хүүхэд төлөбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-
13.2.стратегийн болон томоохон орд газраас олсон орлогоос иргэн бүрт 1.5 сая төгрөг хүртээх эрх зүйн орчин болон санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлж хэрэгжүүлж эхлэх.	хууль батлагдаж, хувь хүртээх ажил эхэлсэн байх	-

13.3. ашигт малтмалын салбарын хөгжлийг түргэтгэх эрх зүйн орчныг шинэчлэх, ашигт малтмалын стратегийн болон томоохон ордуудыг эдийн засгийн эрсэлтэд оруулах замаар хуримтлал бий болгох; 13.4. ядуурлыг тодорхойлох арга-чиглэлийг шинэчлэн боловсруулж, ядуурлын зураглал гаргах бэлтгэлийг ханган, мэдээллийн сангийн нэгдсэн тогтолцоог боловсронгуй болгох; 13.5. ажлын байр шинээр бий болгох замаар хүн амын ажил эрхлэлтийн түвшинг нэмэгдүүлэх;	үйл ажиллагааны хэрэгжилтээр ажил эрхлэлтийн түвшин /хувьнар/ ажлын байр шинээр бий болгох /мян хүн/ дэмжлэгт хамрагдах хүний тоо /мянга/ үйл ажиллагааны хэрэгжилтээр үйл ажиллагааны хэрэгжилтээр стандартууд туршигдсан байх үйл ажиллагааны хэрэгжилтээр хөтөлбөр батлагдсан байх хөтөлбөр батлагдсан байх Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих Сангийн эх үүсвэр /тэрбум төгрөг/ үйл ажиллагааны хэрэгжилтээр нийгмийн хамгааллын дугаарын сүлжээ бүрдэнэ үйл ажиллагааны хэрэгжилтээр мэдээллийн сан бүрдсэн байх	- 63.0 60.0 мянгаас доошгүй 90.0 хүртэл - - - - 3.7 - - - -	- - үзүүлэлт бүрийг 2008 оны мэдээллээр мэдээллээр байгуулах
13.6. хүнсний бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс нийгмийн эмзэг бүлгийнхэнд очиж буй дарамтыг бууруулж, тэдэнд дэмжлэг үзүүлэх;			
13.7. салбарын хөдөлмөрийн үнэлэмж, төлөөс анслагдсан байдал зэргийг хөргөлзөн, инфляцийг зорилгот түвшинд хүрсний дараа уна, тарифыг хөөрөгдөхгүй байхаар төрийн албан хаагчдын цалин төсвийн өрөнхийлөн захирагч нартай зөвшилцөн нэмэгдүүлэх;			
13.8. өндөр насны тэтгэврийг нэмэгдүүлэх;			
13.9. халамжийн үйлчилгээг хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлэх үйлчилгээний стандарт боловсруулж, гэрээлэх нөхцөл бүрдүүлэх;			
13.10. хүн амын насжих хандлагыг утган ахмадын амьдралын чанар, эрүүл мэнд, тэтгэвэрт гарах үеийн болон гарсны дараа нийгэмд идэвхтэй байр сууриа хадгалах зэрэг асуудлыг цогцоор авч үзсэн насжилтын стратеги боловсруулах;			
13.11. хүн амын хөгжлийн идэвхтэй үеийг ашиглах эдийн засаг, нийгмийн төлөвлөлттэй уялдуулах зорилгоор хүн амын хөгжил хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;			
13.12. өрхийн хэрэгцээ, чадавхи, санаачилгад тулгуурлан өрхийн хөгжлийн үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;			
13.13. өрхийн аж ахуйг дэмжих, жижиг зээлийн үйлчилгээг өргөжүүлж, хөдөө орон нутаг, сумдад хүргэх;			
13.14. иргэдийн нэрийн дансны мөнгөийг баталгаажуулах, тэдний нийгмийн даатгалд итгэх итгэлийг нэмэгдүүлж, мэдээллийг ил тод болгох арга хэмжээг хэрэгжүүлэх;			
13.15. малчин бүрийг нийгмийн болон эрүүл мэндийн даатгалтай болгох ажлыг эхлүүлэх;			
13.16. нийгмийн хамгааллын бүртгэлийн тогтолцоог бий болгох;			
13.17. хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэргэжлийн сургалтын төвийг олон улсын жишигт нийцсэн үйлчилгээний шинэ төв болгон өргөтгөх;			
13.18. Манганы хөгжлийн зорилтуудын шалгуур үзүүлэлт, арга зүйг боловсронгуй болгох, хэрэгжилтийг үзүүлэлт бүрээр дүнхэн, хяналт тавих мэдээллийн төрөлжсөн болон тусгай санг угс, аймаг, нийслэлийн түвшинд холбогдох мэдээллээр бүрдүүлэх.			

Зорилт 14. Ерөнхий боловсролын сургуулийг 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлж эхэлсэнтэй холбогдуулан бүх шатны боловсролын чанар, хүртээмжийг дээшлүүлэх:

14.1 сургуулийн өмнөх боловсролын сургалтын агуулга, хөтөлбөрийг сайжруулах;	сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт /хуви/	60.0
14.2 ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн "Удийн цай" хөтөлбөрийг үргэлжлүүлэх;	хамрагдах анги	1-5
14.3 ерөнхий боловсролын сургалтыг 12 жилийн тогтолцоонд шилжүүлэх ажлыг үргэлжлүүлэх;	6 настай хүүхдийн хамран сургалт /хувиар/	95.0
14.4 ерөнхий боловсролын сургуульд түүх, соёлоо дээдлэх, эх оронч үзлийг төлөвшүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх;	12 жилийн тогтолцоонд шилжүүлэх анги, бүлэг	2 болон 7 дугаар анги
14.5 ерөнхий боловсролын сургуулийн 3 ээлжээр ин-ээлэлдэдг байдлыг багасгаж, суралцдын дотуур байрны хуралцаж нэмэгдүүлэх;	-	-
14.6 хөдөөгийн сургуулийн дотуур байрны хангамжийг нэмэгдүүлэх;	шинээр нэмэгдэх дотуур байрны орны тоо	600-аас доошгүй
14.7 "Хүүхэд бүрт компьютер" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх;	хөтөлбөрт хамрагдах хүүхдийн тоо /мян/	20.0
14.8 ерөнхий боловсролын сургуулийн интернэтэд холбох ажлыг эрчимжүүлэх;	цамцгааны байнгын эх үүсвэртэй сумдын тоогоор	-
14.9 ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад мэргэжлийн баримжаа олгох сургалтын хөтөлбөр, агуулгыг боловсронгуй болгох;	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-
14.10 англи хэлний үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэх;	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-
14.11 сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын стандартыг шинэчлэн боловсруулах;	стандарт батлагдсан байна	-
14.12 сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын суралцдын сурлагын амжилтыг үнэлэх тогтолцоог бүрдүүлэх;	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-
14.13 зах зээлийн эрэлт, шаардлагад нийцсэн мэргэжилтэй ажилтан бэлтгэх, хөдөлмөрийн захын эрэлт хэрэгцээний мэдээллийн системийг бүрдүүлэх;	мэргэзлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд элсэгчдийн өсөлт /хувиар/	40.0
14.14 ер бүрээс мэргэжлийн сургалтад хамрагдах хүсэлтээ илэрхийлсэн нэгээс доошгүй хүнийг мэргэшүүлж ажилтай болгох асуудлыг эхлүүлэх;	-	-
14.15 мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийг мэргэжлийн болон мастер багшаар бүрэн хангаж, "Атрын 3 дахь" аян-ы хэрэгжилттэй холбогдуулан газар тариалангийн мэргэшсэн ажилтан бэлтгэхийг дэмжих;	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-
14.16 Өмнөговь аймгийн мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийг Шинэговь ухуан, технологийн их сургуулийн салбар сургууль болгон өргөтгөх;	-	-
14.17 инженер, технологийн чиглэлээр нарийн мэргэшлийн мэргэжилтэн бэлтгэхийг нэмэгдүүлж, дотоодын их, дээд сургууль төгсөөд ажиллаж байгаа инженер, техникийн ажилтан, эмч нарыг төрийн зардлаар гадаадын нэр хүнд бүхий их, дээд сургуульд даатган сургаж мэргэшүүлэх;	инженер, технологийн мэргэжлээр элсэгчдийн өсөлт /хувиар/	25.0
14.18 дотоодын их, дээд сургуульд суралцахаар зөвхөн журмын дагуу элсэж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, Засаг даргын захиалгаар албан ёсоор гэрээ байгуулсан оюутны сургалтын зардлыг төрөөс харьцууцаж мөхөнхийм бий болгож, 2009-2010 оны их-ээллийн жилээс мөрдөх;	гадаагад даатган сургах хүний тоо	250-иас доошгүй
	суралцах оюутны тоо	50 хуртал

14.19. Засгийн газраас жил бүр шаардлагатай мэргэжлийн жагсаалт, ангилал, тоог зарлах, суралтын төрийн сангаас үзүүлж буй эзэл, тусламжийг тодорхой шалгуур хангасан суралцагчдад олгодог байхаар холбогдох журмыг өөрчлөх.	-	-
14.20 хотын хэт төлөрлийг сааруулах, шинэсэх ухааны чадавч ийг дээшлүүлэх ажлын хүрээнд шинжлэх ухаан, технологи, чанартай боловсролын нээлттэй бус буюу их, дээд сургуулийн хотхоныг хотын төвөөс зайдуу газарт барьж байгуулах ажлыг дэмжиж, бэлтгэл ажлыг эхлүүлэх.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-
14.21 шинжлэх ухаан, технологи, инновацийн талаар төрөөс баримтлах бодлогыг шинэчлэн тодорхойлж, технологийн хөгжлийн чиг хандлагыг үйлдвэрлэлтэй уялдуулан хөгжүүлэх.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-
14.22 шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны санхүүжилтэд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-
14.23 өөрийн орны хөгжлийн өнцлөгт томхорсон үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх.	холбогдох хууль батлагдана	-
14.24 биотехнологи, нанотехнологи зэрэг дэвшилтэт технологийн судалгаа, боловсруулалтыг нэмэгдүүлж, туршилт-сорилтын баазыг бэхжүүлэх.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-
14.25 шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлээр нарийн мэргэшсэн эрдэм шинжилгээний ажилтан, залуу судлаач-ыг дотоод, гадаадад болгтгах, давтан сургах, мэргэжлийг нь дээшлүүлэх.	суралцах хүний тоо	100 хүртэл
14.26 соёлын өв уламжлалыг хадгалан хөгжүүлэх ажлын хүрээнд Соёлын тухай хуулийг боловсронгуй болгож, "Монгол Улсын соёл, урлагийг 2004-2021 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө"-г боловсруулж, хэрэгжүүлж эхлэх.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-
14.27 үндэсний уламжлалт соёлын өвөө хадгалж хамгаалах, сэргээн засварлах, хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-
14.28 сумын соёлын төвийн үйл ажиллагааны агуулга, хэлбэрийг бэлжүүлж тогтможуулах, соёлын төвүүдийн барилгыг шинэчилж, засварлах, хөгжмийн зэмсэг, ном, тоног төхөөрөмжөөр хангах замаар хүүхэд, залуучууд, хүн амд хүргэх соёлын үйлчилгээний нийгмийн үр өгөөжийг дээшлүүлэх.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-
Зорилт 15. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн амд тэгш хүртээмжтэй, чанартай үзүүлж, элдэв өвчлөлийг эрс бууруулж, дундаж насалтыг нэмэгдүүлэх, хүн амын өсөлтийг дэмжихэд чиглүүлэх.	чанартай үзүүлж, элдэв өвчлөлийг эрс бууруулж, дундаж насалтыг нэмэгдүүлэх, хүн амын өсөлтийг дэмжихэд чиглүүлэх.	
15.1.хүн амд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээг шинэчилж, Монгол Улсын нутаг дэвсгэрийн ангилалдсан аль ч газарт шаардлагатай үед цаг алдалгүй хүрч тусламж үзүүлэх "Үндэсний турсан тусламжийн сүлжээ" байгуулах ажлыг эхлүүлэх.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-
15.2.эрүүл мэндийн үйлчилгээнд орчин үеийн шинжлэх ухаан, технологийн ололтуудыг нэвтрүүлж, улсын хэмжээнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зайны оношлогооны цахим эмнэлгийн нэгдсэн сүлжээг бий болгох.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-
15.3.эрүүл мэндийн үйлчилгээнд эрхийн бичгийн тогтолцоог нэвтрүүлж, иргэн бүрийг жилд нэг удаа эмнэлгийн их бүрэн, нарийн мэргэжлийн цогц үйлэг оношлогоонд хамруулах ажлыг зохион байгуулж эхлүүлэх.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-
15.4.иргэдийг эрүүл мэндийн орчин үеийн найдвартай, чанартай, хүртээмжтэй үйлчилгээнд хамруулахын тулд төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлэг шинээр байгуулахыг дэмжиж, Улсын төв эмнэлгийн оношлогоо, эмчилгээний өргөтгөлийг шинээр барьж эхлэх.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-

15.5.Орхон аймагт оношлогооны төв байгуулах; 15.6.малчин, ядуу, эмзэг бүтгийн хүн амыг нөхөн үржихүйн эм, хэрэгслээр тогвортой хангах ажлыг үе шатайгаар эхлүүлэх. 15.7 эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чандарын хяналттай уялдуулан эрүүл мэндийн даатгалын тогтолцоог шинэчлэх.	нэн шаардлагатай эмийн хангалт /хувь/ үйл ажиллагааны хэрэгжилтээр	85.0
15.8.эрүүл мэндийн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, төрийн оролцоог багасгах зорилгоор хүн амд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулахад хувийн хэвшлийн мэргэжлийн оролцоог дэмжих, эрүүл мэндийн салбарын санхүүжилтэд хувийн даатгалын тогтолцоог нэвтрүүлэх, эмчийн хэлбэрийг үл харгалзан эмнэлгүүдийг даатгалын үйлчилгээнд жигд хамруулах ажлыг эхлүүлэх; 15.9.халдварт өвчний халдварыг хянааарлах, урьдчилан сэргийлэх, тархалтыг бууруулах арга хэмжээг өргөжүүлж, өвчин эсэргүүцэх тарилга, вакцин, эм хангалтыг нэмэгдүүлэх.	халдварт өвчнийг бууруулах хувь тарилга, вакцины нөөцлөлтийн хувь халдварт өвчнийг эмчлэх эмийн хангалтын хувь	5.0-аас доошгүй 20.0-оос доошгүй 90.0-ээс доошгүй
15.10.төлбөрийн чадваргүй, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эмнэлгийн тусламж хөнгөлөлттэй үнээр олгох тогтолцоог судалж, хэрэгжүүлж эхлэх.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-
15.11.төлбөрийн чадваргүй, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлгийн тусламж, үйлчилгээг үнэ төлбөргүй авах эрхийн бичиг олгох ажлыг эхлүүлэх.	-	-
15.12.жирэмсэн эмэгтэйнчүүд болон ураг, нэрэйд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах, нийслэлд шинээр төрөхийн эмнэлэг барьж ашиглалтанд оруулах, хүүхдийн тусламж, үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлэх.	1000 амьд төрөлтөд ногдоо нөлжсөн эмэгтэйдгйг бууруулах эмийн эсэргүүлийг бууруулах /100000 амьд төрөлтөд/	17 хуртал 69 хуртал
15.13.хүүхдийн амны мэндийн эрүүл мэндийг сайжруулах зорилгоор бүсийн болон аймаг, нийслэлд шүдний кабинет байгуулах ажлыг дэмжих, хэрэгжүүлэх.	байгуулах шүдний кабинетийн тоо	15
15.14.сум, өрхийн эмчийг бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх тогтолцоо болон хөдөө орон нутагт ажиллах эмч нарын урамшууллыг боловсронгуй болгох замаар анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмчийн хангалтыг сайжруулах.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-
15.15.эрүүл мэндийн үйлчилгээнд "Урьдчилан сэргийлэх нь эмчлэхээс хялбар" зарчмыг баримталсан шинэ аргачлал нэвтрүүлэх, хүн амыг эрүүлжүүлэх төвүүдийг байгуулахыг дэмжих.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-
15.16.эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийн эрсдэлт зан үйлийг өөрчлөх, модооллол, сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг үндэсний түвшинд арга зүйгээр хангах тогтолцоог бүрдүүлэх.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-
15.17.нийтийн биеийн тамир, спортын материаллаг баазыг өргөтгөхөд дэмжлэг үзүүлэх, нийтийн биеийн тамир, спортын талаар төрөөс баримтлах бодлогыг батлуулж, хэрэгжүүлж эхлэх.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-

ТАВ.ГАДААД БОДЛОГО, БАТЛАН ХАМГААЛАХ

<p>Зорилт 16. Нээлттэй, олон талуурт гадаад бодлогын хүрээнд улс орнуудтай найрсгаар харилцаж, харилцан ашигтай хамтын ажиллагаа хөгжүүлж, хөгжлийг эрчимжүүлэхэд чиглэсэн орчныг бүрдүүлэх арга хэмжээ авна:</p>	
<p>16.1.Гадаад орнуудын улс төр, эдийн засаг, хөрөнгө оруулалтын бодит сонирхлыг Монгол Улсад бий болгоходоо үндэсний аюулгүй байдал, ард түмний язгуур эрх ашгийн үндэсээ зохицотой тэнцвэрийг хадгалах бодлого явуулах.</p>	<p>үйл ажиллагааны хэрэгжилтээр</p>
<p>16.2.Монгол Улсын хөгжлийг хангах худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруулалтын нэн тавалжтай орчинг бүрдүүлж, Европын Чөлөөт худалдааны нийгэмлэгтэй байгуулсан хамтын ажиллагааны тунхаглалаар хэрэгжүүлэх.</p>	<p>үйл ажиллагааны хэрэгжилтээр</p>
<p>16.3.Дэлхийн худалдааны байгууллагын ДОХА-гын шатны гэрээ хэлэлцээр, НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, далайд гарцуй, эмзэг эдийн засагтай орнуудад үзүүлэх хөнгөлөлттэй хэмжээ, хүрээг тогтоож нэмэгдүүлэхээр ажиллах.</p>	<p>үйл ажиллагааны хэрэгжилтээр</p>
<p>16.4.Дэлхийн худалдааны байгууллагын Хэлэлцээрийн давуу талуу оновчтой ашиглах замаар гадаад худалдааг хөгжүүлж, Монгол Улсын Гадаад худалдааны тэнцлийг сайжруулах;</p>	<p>үйл ажиллагааны хэрэгжилтээр</p>
<p>16.5.Монгол Улсын гадаад худалдааны эрх зүйн орчныг Дэлхийн худалдааны байгууллагын болон олон улсын хууль тогтоомжид нийцүүлэн боловсронгуй болгож худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх таатай орчин бүрдүүлэх;</p>	<p>үйл ажиллагааны хэрэгжилтээр</p>
<p>16.6.худалдаа, хөрөнгө оруулалтын салбарт Европын Холбоо, худалдааны гол түнш орнуудас үзүүлж буй хөнгөлөлтийг өргөжүүлж, экспортыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих бодлогыг хэрэгжүүлэх;</p>	<p>үйл ажиллагааны хэрэгжилтээр</p>
<p>16.7.Үндэсний аюулгүй байдал, газрын тосны бүтээгдэхүүний хангамж, үнийг тогтвортой түвшинд байлгах чиглэлээр экспортологч орнуудтай олон улсын гэрээнд нийцүүлэн удаан хугацааны гэрээ байгуулах санал боловсруулж, хэрэгжүүлэх, импортгоос хамаарах хамаарлыг бууруулах.</p>	<p>үйл ажиллагааны хэрэгжилтээр</p>
<p>Зорилт 17. Гадаад бодлогын үзэл баримтлал, зарчмуудыг даяаршлын үеийн дэлхий дахины шинэ нөхцөл байдал, эх орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, эдийн засаг, нийгэм, батлан хамгаалах бодлогогтой нягт уялдуулан хэрэгжүүлнэ:</p>	
<p>17.1.Гадаад бодлогын тогтвортой байдал, уламжлал, залгамж чанарыг мөрдлөг болгож, олон улсын терроризм, мөнсууруулах бодисын хууль бус наймаа, хүний худалдаа, үндэсний болон олон улсын стандартын шаардлага хангаагүй, үндэсний аюулгүй байдалд шууд нөлөөлөх бараа, бүтээгдэхүүн зэргийг Монгол улсад нэвтрэх нөхцөл боломжийг хаахаар ажиллах;</p>	<p>үйл ажиллагааны хэрэгжилтээр</p>
<p>17.2.Хорш хоёр оронтой харилцан ашигтай, найрсга, тэнцвэртэй харилцааг бүхий л түвшинд хөгжүүлж, АНУ, Япон, Канад, Герман болон Европын Холбооны бусад орнуудтай их бүрэн түншлэлтэй түншинд харилцах бодлого баримтлах, Энэтхэг, БНСУ, Турк, Австрали, АСЕАН-ы орнуудтай түншлэлийн болон худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн хөгжүүлэх;</p>	<p>үйл ажиллагааны хэрэгжилтээр</p>
<p>17.3.Бус нутгийн улс төр, эдийн засгийн харилцаанд идэвхтэй оролцох, Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага /АПЕК/-д гишүүнээр элсэхээр ажиллах;</p>	<p>үйл ажиллагааны хэрэгжилтээр</p>

<p>17.4 далайд гарцгүй орны эрх ашгийг идэвхтэй хамгаалсан бодлогог тууштай явуулж, ОХУ, БНХАУ-ын нутаг дэвсгэр дэргүүр Монголын бараа, бүтээгдэхүүн дамжин өнгөрүүлэх таатай орчныг бүрдүүлэх ажлыг эрчимжүүлэх;</p> <p>17.5 улс орныхоо гадаад сурталчилгаа, соёлын харилцааг зохицуулах хүрээнд гадаад сурталчилгааны үзэл баримтлал боловсруулж, хэрэгжүүлэх;</p> <p>17.6 НҮБ, түүний системийн байгууллагуудын олон талт үйл ажиллагаанд идэвхтэй оролцон олон улсын хамтын нийгэмлэгт эзлэх байр сууриа улам бэхжүүлэх, Мянгана хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд НҮБ, түүний харьяа байгууллагуудтай хамтран ажиллах;</p> <p>17.7 гадаад оронд амьдарч, ажиллаж буй Монгол Улсын иргэдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол, аюулгүй байдлыг хамгаалах ажлыг сайжруулж, тэдэнд үзүүлэх үйлчилгээг хөгжин шуурхай, чанартай болгох;</p> <p>17.8 Монгол Улсын гадаад харилцаа, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны шаварлага, хэрэгцээг хангахад дипломат харилцааны албыг өргөжүүлэн идэвхтэй ажиллуулах.</p>	<p>үйл ажиллагааны хэрэгжилтээр</p> <p>үйл ажиллагааны хэрэгжилтээр</p> <p>үйл ажиллагааны хэрэгжилтээр</p> <p>үйл ажиллагааны хэрэгжилтээр</p> <p>үйл ажиллагааны хэрэгжилтээр</p>	<p>-</p> <p>-</p> <p>-</p> <p>-</p> <p>-</p>
<p>Зорилт 18. Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг батлан хамгаалах нэгдмэл тогтолцоог бэхжүүлэн, бүс нутгийн аюулгүй байдлыг хангах, цэргийн итгэлцлийг бэхжүүлэхэд идэвхтэй оролцож, зэвсэгт хүчний шинэчлэлийн бодлогыг эрчимтэй хэрэгжүүлнэ;</p>	<p>үйл ажиллагааны хэрэгжилтээр</p>	<p>-</p>
<p>18.1 НҮБ-ын мандатын дор явагдаж байгаа энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд Монгол Улсын зэвсэгт хүчний бүрэлдэхүүний оролцоог нэмэгдүүлэх;</p>	<p>үйл ажиллагааны хэрэгжилтээр</p>	<p>-</p>
<p>18.2 Дайчилгааны тухай туульийн дагуу дайчилгааны бэлтгэл нөөцийн 1, 2 дугаар зэргийн бэлтгэл үүрэгтний, төрийн болон орон нутгийн удирдах бүрэлдэхүүний цэрэг-стрателын, цэргийн бэлтгэл сургалтуудыг зохион байгуулах;</p>	<p>үйл ажиллагааны хэрэгжилтээр</p>	<p>-</p>
<p>18.3 "Зэвсэгт хүчний хөгжил сан"-г байгуулан зэвсэгт хүчний цаашдын хөгжлийг хангах эдийн засгийн үндэсийг бүрдүүлэх;</p>	<p>үйл ажиллагааны хэрэгжилтээр</p>	<p>-</p>
<p>18.4 дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг орон нутгт бэлтгэх тогтолцоог төгөлдөржүүлж, бүсийн төвүүдэд байршилтай Зэвсэгт хүчний анги, салбарыг тушаалтан бүсийн сургалтын төвүүдийг үе шаттайгаар байгуулах;</p>	<p>үйл ажиллагааны хэрэгжилтээр</p>	<p>-</p>
<p>18.5 экологийн сүйрэлээс сэргийлэн хамгаалах, ойжуулах, цөлжилттэй тэмцэх, Байгалийн нөхөн сэргээх зэрэг ажил, үүрэг биелүүлэхэд цэргийн дүйцүүлэх албаны оролцоог нэмэгдүүлэх;</p>	<p>үйл ажиллагааны хэрэгжилтээр</p>	<p>-</p>
<p>18.6 НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд үүрэг гүйцэтгэх зориулалт бүхий "Цэргийн цагдаа"-гийн салбарыг шинээр байгуулах ажлыг эхлүүлэх, цэргийн удирдлагын холбоо, мэдээллийн системийг олон улсын жишгт ойртуулан хөгжүүлэх;</p>	<p>үйл ажиллагааны хэрэгжилтээр</p>	<p>-</p>
<p>18.7 Террорист үйлдлийн эсрэг тусгай ажиллагаа болон террорист үйлдлийн хор уршиг, хохирлыг арилгахад оролцох үүрэг бүхий тусгай томигоот анги, салбар, нэгжийн бүтэц, зохион байгуулалт, зэвсэг, техникийг сайжруулж, хөдөлгөөнт чадавгыг нь нэмэгдүүлэх;</p>	<p>үйл ажиллагааны хэрэгжилтээр</p>	<p>-</p>
<p>18.8 Монгол Улсын хил хамгаалалтад орчин үеийн техник, технологийг нэвтрүүлж, хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хууль янхлалтын байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулж, хил хамгаалалтын нэгдмэл тогтолцоог баталгаажуулах.</p>	<p>үйл ажиллагааны хэрэгжилтээр</p>	<p>-</p>

Зорилт 19. Мэргэжлийн хяналтын байгууллагыг бэхжүүлж, үйл ажиллагааг нь идэвхжүүлж, ажлын үр нөлөөг дээшлүүлэн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, хөдөлмөр эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлэхэд чиглүүнэ.

19.1 төрийн хяналтын бодлогын баримт бичгийг шинэчлэн баталж, мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагааг сайжруулах.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-
19.2 хил, гаали, мэргэжлийн хяналтын байгууллагуудын амгын уялдаа холбоог сайжруулж, мэдээллийг нэгдсэн сүлжээнд холбох.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-
19.3 нийтийн боомтод ажиллах газалчид, мэргэжлийн хяналтын байцаагчдын орон сууц, нийтийн асуудлыг шийдэх цогц бодлого боловсруулж хэрэгжүүлэх.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-
19.4 мэргэжлийн хяналтын үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгож, цахим сүлжээнд сууриглан нэг цэгийн үйлчилгээг бий болгох.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-
19.5 хүнсний аюулгүй байдалт тавих хяналтыг сайжруулж, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, хэрэглэгчдийг мэдээллээр хангах.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-
19.6 мэргэжлийн хяналтын байгууллагын лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлж, баталгаажилтын түвшинг дээшлүүлэх.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-
Зорилт 20. Гамшигаас хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг боловсронгуй болгож, учрах хохирлын хэмжээг багасгах чиглэлээр идэвхтэй ажиллана.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-
20.1 гамшийн аюулын зарлан мэдээллийн дохио дамжуулах тогтолцоог бүрдүүлж, онцгой байдлын албаны мэдээллийн тохиок болон програм хангамж, мэдээллийн сүлжээг орчин үеийн техник, технологийг шинэчлэх.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-
20.2 улс оронд гарч болзошгүй гамшигын төрлүүдэд зохицон ажиллах боломж бүхий радио холбооны зангилаа, тухайн гамшийн голомтоос уяардлагад шуурхай мэдээлэл дамжуулах радио сувгийг байгуулах.	холбооны радио сүлжээтэй болох	-
20.3 онцгой байдлын албаны болтлоо, бэлэн байдлыг хангах, гамшигтай тэмцэх чадавхийг дээшлүүлж, техник, зэвсэглэмжийн хангалтыг сайжруулах, томоохон хот, суурин газар, аврах шуурхай бүлэг 105-ыг байгуулах.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-
20.4 гамшигаас өөрийгөө болон бусдыг хамгаалах боловсролыг иргэдэд олгох сургалтын тогтолцоог сайжруулах.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-
20.5 гамшийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хамгаалах, хор уршгийг арилгах зорьд шинжилгээ, судалгааны ажлын үр дүн, шинжлэх ухаан, технологийн олголттой өргөнөөр нэвтрүүлэхийг дэмжих.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-
20.6 орон нутгийн онцлог, тохиолдож болзошгүй гамшигын нөхцөл байдал зэрэгтэй уялдуулан улсын нөөцийн байршлыг өөрчлөх, нэмэгдүүлэх асуудалт судалж, шийдвэрлүүлэх.	Улсын нөөцийн сангийн тухай бодлого шинэчлэгдсэн байх	-
20.7 Улсын нөөцийн салбарын агуулахын аж ахуйн материаллаг баазыг бэхжүүлж, Улаанбаатар хотод 60 000 м ³ багтаамжтай улсын нөөцийн шатаахун хадгалах орчин үеийн терминал байгуулах, хүнсний бараа, материал хадгалах орчин үеийн иж бүрэн механикжсан агуулахыг шинээр бийрүүлэх ажлыг судлах.	агуулахын багтаамж /куб метр/	60000
20.8 гамшигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, хор уршгийг нь арилгахтай холбогдсон нэгдсэн мэдээллийн тогтолцоог бий болгож, гамшийн мэдээллийн сан байгуулж, хорш орнууд, бүс нутгийн гамшигаас сэргийлэх хамтарсан үйл ажиллагаанд нэгдэх, уялдуулах арга хэмжээ авах.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-
20.9 бүс нутгийн болон дэлхийн улс гүрнүүдийн ижил төст чиг үүрэг гүйцэтгэдэг байгууллагуудтай харилцаа тогтоож замаар байгуулганыхаа ирээдүйн хөгжил дэвшлийг хангахад гадаад хүчин зүйлийг бүрэн ашиглах нөхцөлийг бүрдүүлэх.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-

Монгол Улсын Их Хурлын 2008 оны
40 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт

**ОЮУ ТОЛГОЙН ЗЭС-АЛТНЫ ОРДЫГ ХАМТАРЧ
АШИГЛАХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГЭРЭЭ
БАЙГУУЛАХ ҮНДСЭН ЗАРЧИМ, УДИРДАМЖ**

1. Хөрөнгө оруулалтын гэрээг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжуудад нийцүүлэн хийх.

2. Гэрээг байгуулахдаа дараахь хувилбаруудыг судлан үзэх:

1/ Монголын талын эзэмшлийг 34 хувиас эхэлж, анхны хөрөнгө оруулалтаа нөхсөний дараа 50 хувь болгох асуудлыг гэрээнд тусгах хувилбар;

2/ Бүтээгдэхүүн хуваах зарчимд тулгуур-ласан хувилбар.

3. Ордыг түшиглэн байгуулагдах компанийн хувьцааны 34 хувийг Монголын тал шууд эзэмшижээр тооцож, уг хувьцаанд ногдох хөрөнгийг албан татвар, төлбөр, хураамж, ногдол ашг, зээл зэрэг хэлбэрээр оруулж болохоор тохиролцох.

4. Гэрээнд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, албан татварын тодорхой хэсгийг урьдчилан авахаар тохиролцох.

5. Ордыг ашиглахтай холбогдуулан шинээр барих эрчим хүч, авто зам, төмөр зам, усан хангамж зэрэг дэд бүтцийн холбогдолтой барилга байгууламжуудын болон хот тосгон, нийгэм, соёлын асуудлыг хэрхэн шийдэх талаар гэрээнд тусгах.

6. Эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зарчим баримталж, үйлдвэрлэлийн шат дамжлага, гаргах бүтээгдэхүүний нэр төрлийг тохиролцох.

7. Үйлдвэрлэлд ажиллах үндэсний боловсон хүчнийг бэлтгэх хөтөлбөр, төлөвлөгөөг тохиролцох.

8. Байгаль орчин, хүн, амьтанд хор хөнөөлгүй, орчин үеийн шилдэг техник, технологийг ашиглах талаар болон байгаль орчны нөхөн сэргээлтийн ажлыг ордын хайгуул, ашиглалтын бүхий л үе шатанд хэрэгжүүлэх талаар гэрээнд тусгах.

9. Гэрээний төсөл боловсруулахдаа олон улсад нэр хүнд бүхий зөвлөх үйлчилгээ үзүүлэгч байгууллагын туслалцааг авах.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 12 дугаар
сарын 04-ний өдөр

Дугаар 41

Улаанбаатар
хот

**Зээлийн ерөнхий хэлэлцээрт нэмэлт,
өөрчлөлт орсонтой холбогдуулан
авах арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24.6 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд 2005 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр байгуулсан "300.0 сая ам. долларын экспортын хөнгөлөлттэй зээлийн ашиглалтын талаархи Зээлийн ерөнхий хэлэлцээр"-г оруулсан нэмэлт, өөрчлөлтийг Улсын Их Хурлаар соёрхон баталсантай холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /С. Баяр/-г даалгасугай.

1/ тус зээлийн хөрөнгөөр "Баруун бүсийн авто зам", "Орон сууцны хороолол /инженерийн дэд бүтэц, барилгын материал/", "Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний паркийг

нэмэгдүүлэх", "Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах", "Мэдээлэл холбооны нэгдсэн сүлжээний шинэчлэл" төслийг санхүүжүүлэх;

2/ энэхүү хэлэлцээрийн талаархи мэдээллийг олон нийтэд хүргэж, зээл олгох үйл ажиллагааг нээлттэй, ил тод байдлаар явуулах нөхцөлийг ханган, зээлийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Зээлийн ерөнхий хэлэлцээрийг соёрхон баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2008 оны 6 дугаар сарын 09-ний өдрийн 49 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Д. ДЭМБЭРЭЛ**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 265958
Индекс 14003

☎ 329487
Хэвлэлийн хуудас 6.5